

“ХӨХ ГАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Улаанбаатар хот

“Хөх ган” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр БиДиСек ҮЦК ХК-ийн төв байрны 201 тоотод 14:00 цагт эхлэв.

Тооллогын комиссын ирцийн тогтоолоор хурлын ирц 83.49%-иар хүчин төгөлдөр болов.

Хурлын дарга: Хурлыг нээж компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан болон 2019 оны төлөвлөгөөг танилцуулав.

Асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигч: Авлага бий юу?

Хариулт: Бэрэн металл ХХК-с 1,5 тэрбумын авлага бий.

Хувьцаа эзэмшигч: Бэрэн металл ХХК хэзээ ашиглалтанд орох вэ?

Хариулт: Төлөвлөгөөгөөрөө бол энэ оны 8 сард байгаа.

Хувьцаа эзэмшигч: Ажилчид хэр байгаа вэ?

Хариулт: Одоогийн байдлаар барилга болон тоног төхөөрөмжийн зарим засварууд хийгдэж үйлдвэрийг асаахад бэлдэж байгаа. 2018онд бид 20-оод ажилтантай үйлдвэр асаахад засварын болон цэвэрлэгээний ажлууд хийгдсэн.

Хувьцаа эзэмшигч: Ажиллаж эхлэвэл хүн нэмж авах уу,

Хариулт: Хуучин ажиллаж байсан хүмүүсийн 50 орчим хувь нь эргэж ажиллахаар байгаа. Үлдсэн 50-60 хүнийг сургаж ажиллуулах төлөвлөгөөтэй байна

Хувьцаа эзэмшигч: Дархан төмөрлөгт ган бөмбөлөг нийлүүлж байгаа юу?

Хариулт: Хөх Ган ХК нь ган бөмбөлөг үйлдвэрлэгдэггүй харин түүний түүхий эдийг бэлтгэдэг үйлдвэр юм.

Хувьцаа эзэмшигч: Үйлдвэрлэл эхлэвэл худалдан авагч байгаа юу?

Хариулт: Бэрэн металл ХХК ажиллаж эхлэвэл манай бүтээгдэхүүнийг 100% худалдан авах байгаа мөн экспортод бүтээгдэхүүнээ гаргах төлөвлөгөөтэй байна.

Хувьцаа эзэмшигч: Хүчин чадлаа нэмэгдүүлэх хэрэгтэй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч: Улсаас төмөрлөгийн үйлдвэрүүдийг дэмжих төсөл арга хэмжээнүүд явагдаж байгаа. Очиж уулзсан юм байгаа юу?

Хариулт: Улсаас хэрэгжиж буй төсөлд тодорхой хэмжээгээр оролцоод явж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Хөх ган ХК нь ажиллаж эхэлсэнээсээ хойш ногдол ашиг нэгч тарааж байгаагүй. Дундын дамжлагын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэж байна. Ийм төсөлд санхүүжилт татаж 30гаран хувийг эзэмшиж байгаа БиДиСЕК-ийн буруу гэж харж байна.

Хариулт “БиДиСЕК” ХК: “БиДиСЕК” ХК нь андеррайтерын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд энэ төсөлд хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах ажлыг гэрээний хүрээнд зохион байгуулсан. Тухайн үед танилцуулга гээд бүх зүйлийг л хийсэн. Үүнд андеррайтерийн компанийн буруу гэж үзэж болохгүй юм.

Хариулт “Хөх Ган” ХК: “Хөх Ган” ХК нь 2013 оноос хойш алдагдалтай ажиллаж байсан. 2014-2015 оноос эхлэн төмрийн үнэ унасантай холбоотой үйлдвэрлэл удаан хугацаагаар зогссон. 2018-2019 оноос төмрийн үнэ тогтворжин үнэ өсөх хандлагтай байгаа бөгөөд энэ оноос эхлэн тогтвортой ажиллаж эхний ээлжинд шаардлагатай түүхий эдийн санхүүжилт хэрэгтэй байгаа. 2019 ондоо татварын өмнөх ашгаараа 688 саяын ашигтай ажиллах төлөвлөгөөтэй байгаа.

“БиДиСЕК” ХК: Тооллогын комиссын гишүүн саналын хуудас бөглөх зааврыг танилцуулав санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комиссын дүн:**Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.**

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 84,595,655 ширхэг хувьцаатай 10 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
84,595,655	100%	0	0%	0	0%

2. Компанийн 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 84,595,655 ширхэг хувьцаатай 10 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
84,595,655	100%	0	0%	0	0%

3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 84,595,655 ширхэг хувьцаатай 10 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
84,595,655	100%	0	0%	0	0%

4. Саналын хуудсаар "Хөх ган" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 84,595,655 ширхэг хувьцаатай 10 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
84,595,655	100%	0	0%	0	0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 99.98% буюу 84,575,630 ширхэг хувьцаатай 8 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр	Саналын	Кумулятив аргаар өгсөн
---	----------------------------	---------	------------------------

	дэвшигчдийн нэрс	хувь	саналын тоо
1	Бэрэнбарал Мөнхтөр	15.73688%	79,857,397
2	Цэдэнсодном Батбаяр	15.73688%	79,857,397
3	Цэдэнсодном Батболд	15.73688%	79,857,397
4	Данзан Даянбилгүүн	18.52425%	94,002,009
5	Ганзориг Энхболд	15.73688%	79,857,397
6	Бүрэнмэнд Лхагвадорж	18.52425%	94,001,999
7	Нарангэрэл Батгэрэл	0.00398%	20,184

Тус тус санал авч дараах гишүүд ердийн гишүүнд сонгогдов. Үүнд:

1. Б.Мөнхтөр
2. Ц.Батбаяр
3. Ц.Батболд
4. Д.Даянбилгүүн
5. Г.Энхболд
6. Б.Лхагвадорж

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
8	Баярсайхан Алтансүвд	21.69502%	55,046,088
9	Дашцэрэн Энхбат	20.98459%	53,243,539
10	Данпунцаг Чинбат	20.98458%	53,243,529
11	Халтар Батхишиг	36.33582%	92,193,734

Тус тус санал авч дараах гишүүд хараат бус гишүүнд сонгогдов. Үүнд:

1. Б.Алтансүвд
2. Д.Энхбат
3. Х.Батхишиг

Тооллогын комиссын дарга:

Тооллогын комиссын гишүүн:

[Signature]

[Signature]

/С. Алтанцэцэг/

/Л. Бямбадорж/

/Д. Шүрэнцэцэг/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын дүнг Тооллогын комисс дэгийн дагуу танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэл, саналын хуудас, Тооллогын комиссын тогтоол №1,2-ийг тус тус тэмдэглэлд хавсаргав.

Хурлын дарга хурал хааж үг хэлснээр хурал 16:20-т дуусав.

Хурлын дарга:

/Д.Мөнхбазар/

Тэмдэглэл хөтөлсөн:

/Цэцэгдэмбэрэл /

